

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Б.ЭНХБАЯР

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
ХАМААРАХ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ
ЗОРИЛГООР ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
БОЛОН БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газар “Хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.” гэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт “5.5.Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.”-ыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “1.Хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ.” гэж заасан.


1.2.Практик шаардлага

Монгол Улсад төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай бөгөөд нийт ард түмнээс сонгогдож байгуулагдсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллага болохын хувьд хууль тогтоох онцгой бүрэн эрхийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр Үндсэн хуульд хуульчлан тогтоосон.

Энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас ардчилсан шинэ нийгмийн харилцааг төлөвшүүлэх, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор олон хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцыг батлан мөрдүүлж байна. Тухайлбал, Монгол Улс байнгын ажиллагаатай парламенттай болж, 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан мөрдүүлснээс хойш өнөөг хүртэл хугацаанд¹ Улсын Их Хурлаас нийт 885 хуулийг хэлэлцэн баталжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг хянаж, бүртгэх, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, жил бүр хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайлан, дүнг нэгтгэн судалж, авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Энэхүү чиг үүргийн хүрээнд өнгөрсөн онд тус яамнаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаас үзэхэд дээрх нийт батлагдсан хуулиас 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 437 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд үүнээс 315 хуулийн 2403 заалтаар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон хуульчилсан дэд акт батлах эрхийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллага, нийтийн эрх зүйн бусад этгээдэд олгосон байна.



Зураг 1.

Харин захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 1553 эрх олгосон заалтыг үндэслэн баталсан 2357 шийдвэр бүртгэлтэй, 850 эрх олгосон заалтын дагуу холбогдох хэм хэмжээ тогтоосон захиргааны акт бүртгэлгүй буюу батлагдсан эсэх нь тодорхойгүй байдалтай байна.²

Хууль тогтоогч нийгмийн харилцааг зохицуулах шаардлагатай бүхий л эрх зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэх боломжгүй байдаг. Учир нь хууль тогтоогчийн хүсэл зоригийг тухай бүр хуульд тусгах боломжгүй стандарт, техникийн зохицуулалт агуулсан, эсхүл зохион байгуулалтын шинжтэй дүрэм, журам, эсхүл маягт, загвар, хувь хэмжээ тогтоох зэрэг нийгмийн харилцааны хөгжил, өөрчлөлтөөс хамааран тогтвортой үйлчлэх боломжгүй онцлог зарим асуудлыг батлан мөрдүүлэх эрхээ зохих этгээдэд шилжүүлэх байдлаар хуульчилдаг.

Хууль, хэм хэмжээний акт хоорондын хамаарлыг (ялгааг) тодорхойлохдоо суурь болгодог үзэл онол нь **парламент тусгаар улсын илэрхийлэл бөгөөд бүрэн, дээд хүчин чадалтай** (“*Parliamentary sovereignty*” and “*Parliamentary supremacy*”³) буюу Монгол Улсын Үндсэн хуулийн “төрийн эрх барих дээд байгууллага” гэсэн зохицуулалтай дүйхүйц ойлголт юм. Ардчилсан тогтолцоотой улс “эрх зүйт ёс”-нд захирагдах бөгөөд төрийн дээд эрх нь хууль тогтоох замаар хэрэгжих учир зөвхөн энэ эрхийг хэрэгжүүлж буй этгээдэд “төрийн эрх барих дээд” чиг үүрэг хадгалагдана гэсэн санаа юм. Үүний зэрэгцээ, хууль тогтоох эрх нь гүйцэтгэх эрх мэдлийг хянах боломжтой байх нь парламентийн бүрэн, дээд хүчин чадлыг илтгэнэ гэж үздэг. Хууль, хэм хэмжээний актын харьцаа, хамаарлыг тодорхойлоход⁴ юун түрүүнд, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт нь ардчилалын зарчмын (*democratic legitimacy*) үүднээс хүлээн зөвшөөрөгдөх магадлал нь хуультай харьцуулахад дутмаг, дараагийн дугаарт, хэм хэмжээний акт нь зөвхөн шилжүүлсэн эрхийг цааш нарийвчлан хэрэгжүүлэх зорилгыг агуулдаг, түүгээр хязгаарлагдагт оршиж байна.⁵

Улс орнууд захиргааны хэм хэмжээний акт тогтоох эрх шилжүүлэх заалтад урьдчилсан болон дараах хяналт тогтоох механизм бий болгох замаар тодорхой цenzуртай ханддаг бөгөөд энэ талаар хууль тогтоомжидоо тодорхой зааж тусгаж өгсөн нь ч байна.

Монгол Улсын хувьд захиргааны хэм хэмжээний актын дээрх судалгаа, хяналт-шинжилгээний тайлангаас үзэхэд, энэхүү хуулиар эрх шилжүүлэх байдал хэт өргөжсөнөөс сүүлийн жилүүдэд улсын нэгдсэн санд бүртгүүлэх захиргааны хэм хэмжээний актын тоо тогтмол өсөлттэй байна.

Он дарааллаар	Нийт хүчинтэй шийдвэрийн тоо	Өмнөх онтой харьцуулсан дүн
2010	681	
2011	752	10.4 %
2012	799	6.3 %
2013	843	5.5 %
2014	952	12.9 %
2015	1012	6.3 %
2016	973	-3.9 %
2017	850	-12.6 %
2018	906	6.6 %
2019	1357	49.8 %
2020	1653	21.8 %
2021	2202	33.2 %
2022	2240	1.7 %
2023.10 сар	2357	5.2 %



Зураг 2.

Тухайлбал, улсын нэгдсэн санд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний актын тоо 2010 онд 681 байсан бол 2023 онд 2357 болж, энэ хугацаанд 3.5 дахин нэмэгдсэн байна. Энэ тоонд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан шийдвэрийн тоо ороогүй болно⁶.

Ийнхүү Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй 437 хуулиас гадна хуулиар эрх олгосон 2403 заалтын хүрээнд 2357 хэм хэмжээ тогтоосон захиргааны актаар нийгмийн харилцааг зохицуулж байгаагаас үзвэл Монгол Улсын нийт хууль болон хуульчилсан актын бүтцэд захиргааны хэм хэмжээний актын эзлэх хувь давамгайлж, хоорондын тэнцвэр алдагдаж, харилцан нөлөөлөх хэмжээнд хүрч, Монгол Улс “журмын улс” болсон байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон “Хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдах”, “хууль бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн байх” зарчимд нийцэхгүйн зэрэгцээ нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ “тогтвортой” байх гол шинж алдагдах, улмаар нийгмийн харилцааг төлөвшүүлэхэд сөрөг үр дагавартай юм.

Эдгээр актад дүн шинжилгээ хийж үзэхэд, эрх олгосон заалт агуулсан ихэнх хуульд тухайн захиргааны хэм хэмжээний актын ерөнхий нэр, батлах субъектыг томъёолсноос бус ямар төрлийн харилцааг хэрхэн зохицуулах, түүний хүрээ, хязгаарыг оновчтой тодорхойлсон нь ховор байна.

Мөн хуулийн төслийг боловсруулж байгаа төрийн захиргааны төв болон бусад байгууллагууд хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг тухайн хуульд бүрэн тусгах гэхээс илүүтэй эрх олгосон заалтаар зохицуулах хувилбарыг сонгох нийтлэг хандлагатай, хуулийн төслийг процесжуулан бичих мэдлэг, туршлага дутмаг байна.

Ийнхүү тусгайлан эрх олгосон заалт олноор тусгаж, баталсан хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахад практикт төрийн байгууллагууд олон дүрэм, журам боловсруулах, санал авах, батлах зэргээр ихээхэн хугацаа шаардаж, зарим тохиолдолд тухайн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн боловч холбогдох хэм хэмжээ тогтоосон захиргааны акт батлагдаагүйн улмаас хууль нэг мөр хэрэгжих боломжгүйд хүрч байна.

Тухайлбал, Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Төрийн албаны тухай хуулиар 24 эрх олгосон заалт, 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хууль 40 эрх олгосон заалт, Нийгмийн даатгалын ерөнхий хууль 25 эрх олгосон заалт, 2019 онд батлагдсан Татварын ерөнхий хууль 28 эрх олгосон заалтыг тус тус хуульчилсан байна.

Эдгээр эрх олгосон заалтын хүрээнд хууль батлагдсаны дараа төрийн албан хаагчид дүрэм, журам боловсруулах үндсэн ажилтай болж, тэдгээрийн ажлын ачааллыг ихээр нэмдэг бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарч, богино хугацаанд дүрэм, журмыг “үйлдвэрлэдэг”. Үүнээс шалтгаалан практикт захиргааны хэм хэмжээний акттай холбоотой дараах нийтлэг давхардал, хийдэл, зөрчлийг үүсгэж байна. Үүнд:

1/тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнээс хальсан, эсхүл хуулиас давсан зохицуулалт, хэм хэмжээ тогтоох, бусад хууль тогтоомжтой зөрчилдөх;

2/хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоох;

3/авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалтны дур зорго үүсгэх нөхцөл бий болгох;

4/төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртал гарах нөхцөлийг бүрдүүлэх;

5/хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарлах;

6/эдийн засаг, нийгмийн харилцаанд болон бусад үйл ажиллагаанд хориг саад учруулах.

Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актын талаар хууль бус тул хүчингүй болгуулах талаарх Захиргааны хэргийн шүүхэд хандан нэхэмжлэл тохиолдол нилээдгүй байна. тухайлбал захиргааны хэм хэмжээний актад холбогдуулан нэхэмжлэл гаргасан маргааныг шийдвэрлэсэн байдлыг харвал: анхан шатны шүүхийн 24 шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 15 магадлал, хяналтын шатны шүүхийн 9 тогтоол, давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн 30 шийдвэр, хяналтын шатны шүүхийн 26 шийдвэр⁷, нийт 104 шүүхийн шийдвэр байна. Энэ нь цаашид эрх зүйн соёл, ухамсар нэмэгдэхийн хэрээр захиргааны байгууллагыг гаргасан шийдвэрийн үндэслэлийг хянуулах шүүхэд хандах явдал нэмэгдэх тул холбогдох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар анхаарах нь зүйтэй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дээрх асуудлыг анхаарч, захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд тус хуралдаанаас Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг даалгасны дагуу хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй 35 хуулиар 160 гаруй дүрэм, журам батлах эрхийг Засгийн газар, Засгийн газрын гишүүн болон агентлаг, байгууллагын даргад олгосон байгааг судалж үзээд тэдгээрийн 50 орчим хувь нь зайлшгүй хуулиар зохицуулах ёстой буюу хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан байгааг хуулийн төсөл болгон боловсруулж, холбогдох хуулиудад тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Ийнхүү авлигажих, хүнд суртал, дур зорго үүсэх, хүний эрхэд халдах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхэд хүргэж буй хуулиар журам батлах эрх олгосон зарим зохицуулалтаас татгалзаж, хүчингүй болгох, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа холбогдох зохицуулалтыг хуульд тусгаж, холбогдох хуулийн төслүүдийг боловсруулах замаар хууль зүй, дотоод хэргийн салбарын хуулиудыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсад хэм хэмжээ тогтоосон акт гаргах эрх хуулиар олгоход баримтлах “хууль, захиргааны хэм хэмжээний актын харилцан хамаарал, зааг, хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны ялгаа, хамрах хүрээний талаар” зохицуулалтыг мөн холбогдох хуульд тусгах, цаашид хэм хэмжээний акт батлах эрх олгосон заалтын урьдчилсан хяналтыг боловсронгуй болгох шаардлага байна.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор дараах нэр бүхий хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна. Үүнд: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг нийт 25 хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төслийг боловсруулах үндсэн зарчим нь тухайн хуулийн үзэл баримтлалыг хөндөхгүй бөгөөд хуулиар эрх олгосны дагуу батлагдсан дүрэм журмаар зохицуулагдаж байгаа харилцаанаас хүний эрх, эрх чөлөөг хөндсөн зохицуулалт тусгасан, тухайн харилцаанд оролцогчийн үндсэн эрх, үүргийг тогтоосон буюу процедурыг журамласан, тодорхой этгээдэд зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан, бусад хууль тогтоомжийн зохицуулалттай давхардал үүсгэж байгаа захиргааны хэм хэмжээг холбогдох хуульд тусгах, дүрэм журам гаргах шаардлагагүйн улмаас өнөөг хүртэл батлагдахгүй байгаа эрх олгосон заалтыг хүчингүй болгох, хэд хэдэн хуулиар нэг төрлийн харилцааг зохицуулах хэм хэмжээ батлах эрхийг давхардуулан олгосон байгаа давхардлыг арилгах гэсэн чиглэлээр хуулийн төслүүдийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаарх санал

Одоо журмаар зохицуулж байгаа харилцааг холбогдох хуулиар зохицуулах бөгөөд ингэснээр хууль тогтвортой, нэг мөр хэрэгжих, хуульд процессын хэм хэмжээ бүрэн туссанаар захиргааны байгууллага, албан тушаалтан дур зоргоор хэм хэмжээг тогтоох, иргэдэд хуулиас давсан үүрэг хүлээлгэх байдал хязгаарлагдаж, иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Хууль тогтоомжийн системчлэл, хуулийн төсөл боловсруулах техникт дэвшил гарч, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилна. Түүнчлэн, цаашид хуулийн

төсөлтэй хамт дагаж гарах бусад шийдвэрийн төслийг боловсруулдаг байдал хэвшинэ.

Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төсөлд хэм хэмжээ тогтоох эрх шилжүүлсэн заалт тусгах хүрээ хязгаар, шаардлагыг тусгаж өгснөөр Үндсэн хуулийн эрх мэдэл хуваарилах зарчмын үзэл баримтлал хангагдах, хуулийн төслийн боловсруулалт сайжрах эерэг үр дүн гарна.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Хуулийн төслүүд нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төслүүдийг дагалдуулан Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

-----ooOoo-----